2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,581.78
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	164,581.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,010.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,382.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	625.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	625.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,757.91
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,757.91
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	221,517.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	221,517.82
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	159,049.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	62,468.72

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн захирагч С.Эрдэнэболд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 22-оос 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Хэрлэнчимэг гүйцэтгэв.

Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 05/151 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын эрхэм зорилго, зорилт

Хатанбулаг сум нь сумын эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд хөгжлийн алсын харааг “Амьдрах арга, нийгэмших чанар, төрт ёс, уламжлалаа шүтсэн оюунлаг иргэн, хүнээ дээдэлсэн чадварлаг удирдлагатай, олон салбар бүхий хөгжингүй эдийн засагтай, орчин үеийн хөгжлийн түвшинд хүрсэн өлгий нутаг болно” гэж тодорхойлсон байна.

Хөгжлийн хэтийн төлөвлөгөөнд дараах зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд,

1. Бизнесийн таатай орчинг бүрдүүлэх,
2. Хөдөө, аж ахуй, аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх,
3. Нутгийн удирдлагын чадавхыг дээшлүүлэх,
4. Бүх шатны удирдлагын түвшинд хүний хөгжлийг анхаарлын төвд байлгах.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус сумын санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд дотоод хяналт хийгдээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт төсвийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны батлагдсан төсөв болох 853.3 сая төгрөгийн 1 хувь буюу 8.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын сонгосон суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн батлагдсан төсөв /2020 оны 12 дугаар сард тодотгосон төсөв/ болох 3,552.0 сая төгрөгөөс 1 хувиар тооцож, 35.5 сая төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 110.0 сая, эцсийн үлдэгдэл 92.3 сая төгрөг болж, 17.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	110.0	92.3	-17.7	100
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	110.0	92.3	-17.7	100

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 92.3 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 135.9 сая, эцсийн үлдэгдэл 189.0 сая төгрөг болж, 53.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	28.5	28.5
Зээлийн хүүгийн авлага	6.1	1.0	-5.1
Бусад авлага	13.0	5.2	-7.8
Зээлийн авлага	116.8	154.3	37.5
Дүн	135.9	189.0	53.1

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 62.3 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэл болох 61.3 сая төгрөгийн авлага,
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн үлдэгдэл болох 1.0 сая төгрөгийн авлага,

Аудитын илрүүлэлт:

- Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 20 зээлдэгчийн 155.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Уг зөрчлийг ТТЗ-ын аудитын явцад арилгаж, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан болно.

- Тус сумын сургууль нь тайлант онд татварын байгууллагаас 4.1 сая төгрөгийн авлагатай ажиллаж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 267.3 сая, эцсийн үлдэгдэл 279.6 сая төгрөг болж, 12.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	94.9	110.9	16.0
Эм боох материал	12.3	31.7	19.4
Бичиг хэргийн материал	20	22.6	2.6
Аж ахуйн материал	60.2	58.4	(1.8)
Сэлбэг хэрэгсэл	8.1	2.1	(6.0)
Түлш шатах тослох материал	21.4	8.6	(12.8)
Хүнсний материал	12	8.8	(3.2)
Бусад хангамжийн материал	12.1	10.1	(2.0)
Мал амьтад	26.3	26.4	0.1
Дүн	267.3	279.6	12.3

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авч нөөцөлсөн, мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал бүртгэгдээгүй байна.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,913.3 сая, эцсийн үлдэгдэл 5,497.6 сая төгрөг болж, сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	2,507.7	3,691.3	1,183.6
Авто-тээврийн хэрэгсэл	103.3	200.6	97.3
Машин тоног төхөөрөмж	179.3	255.3	76.0
Тавилга эд хогшил	89.0	123.6	34.6
Түүх соёлын дурсгалт зүйлс	5.3	25.2	19.9
Бусад үндсэн хөрөнгө	791.3	957.5	166.2
Ном	36.8	36.8	-
Программ хангамж	0.3	7.0	6.7
Бусад биет бус хөрөнгө	200.3	200.3	-
Дүн	3,913.3	5,497.6	1,584.3

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 124.1 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,829.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба хасагдсан үндсэн хөрөнгө бүртгэгдээгүй байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6.1 сая, эцсийн үлдэгдэл 1.7 сая төгрөг болж, 4.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
----------	-------------------	-----------------	---------------------	--------------------

Богино хугацаат өр төлбөр дүн	6.1	1.7	-4.4	100
Бусад өглөг	5.5	1.4	-4.1	82.4
Ажиллагсадтай холбогдсон өглөг	0.6	0.3	-0.3	17.6
Нийт дүн	6.1	1.7	-4.4	100

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн дүнд нийгмийн даатгал болон татварын байгууллагад төлөх өр төлбөр, сум хөгжүүлэх санд данс андуурсан гүйлгээг буцаан өгөх өр төлбөр, аймгийн орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх хөрөнгийн түрээсийн төлбөрийн өр төлбөр бүртгэгдсэн байна.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,420.3 сая, эцсийн үлдэгдэл 6,056.8 сая төгрөг болж, 1,636.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал -Засгийн газрын сан, орон нутгийн сан	2,284.1	2,284.1	-	37.7
Хуримтлагдсан үр дүн	1,314.5	2,951.0	1,636.5	48.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	821.7	821.7	-	13.6
Дүн	4,420.3	6,056.8	1,636.5	100

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,056.8 сая төгрөг болж, 1,636.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үүнд:

- Хуримтлагдсан үр дүн 2,951.0 сая төгрөг болж 1,636.5 сая төгрөгөөр өссөн нь нэгтгэлд хамрагдсан 14 байгууллага, сан ашигтай ажилласнаас шалтгаалжээ.

3.5.8 Орлогын данс

Тайлант онд нийт 5,419.1 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Үүнд, татварын орлого 1,331.2 сая төгрөг, татварын бус орлого 2,012.3 сая төгрөг, үндсэн болон нэмэлт санхүүжилтийн орлого 2,075.6 сая төгрөгийн орлогыг бүртгэсэн байна.

Татварын 8 төрлийн орлогыг бүрдүүлж ажилласан байна. Татварын бус орлогод хүү, торгуулийн орлогоос 27.8 сая төгрөг, бусад төлбөр хураамжаас 15.5 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 100.2 сая төгрөг, зээлийн хүүгийн орлогоос 3.7 сая төгрөгийг бүрдүүлсэн ба үнэ төлбөргүй 1,828.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 36.1 сая төгрөгийн бараа материалыг орлогод тусгасан байна.

Улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 1,295.4 сая төгрөг, ОНХС-ийн шилжүүлгээр 402.3 сая төгрөг, боловсрол болон эрүүл мэндийн байгууллагын тогтмол зардалд 131.2 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн байгууллагын урсгал зардалд 29.5 сая төгрөг, нэмэлт санхүүжилтээр урсгал зардалд 217.2 сая төгрөг, нийт 2,075.6 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Аудитын илрүүлэлт:

-ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй орон сууцны 2 түрээслэгч иргэн түрээсийн төлбөрийг 0.3 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

-Тус байгууллага нь аймгийн орон нутгийн орлогын дансанд 0.4 сая төгрөгийн түрээсийн орлогын төлбөрийг дутуу төвлөрүүлсэн байна.

-Тайлант онд сумын ЗДТГ нь туслах үйл ажиллагааны орлогоос 7.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч, гүйцэтгэлээр 5.7 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 1.3 сая төгрөгөөр тасалсан байна.

3.5.9 Зардлын данс

Тайлант онд нийт 3,782.6 сая төгрөгийн зардал гаргасан байна. Нийт зардалд материаллаг хэмжээний цалин хөлсний зардал 1,313.3 сая /34.7 хувь/, хангамж бараа материалын зардал 1,234.8 сая /32.7 хувь/, үүнээс ОНХС-аар хийгдсэн 1,115.6 сая төгрөгийн ТАХ-г ашиглагч байгууллагад шилжүүлснийг зардлаар тусгасан, бараа, үйлчилгээний бусад зардал 404.7 сая /10.7 хувь/, үүнд үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардал 369.4 сая төгрөг байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 14/05 дугаар тогтоолд зааснаар Хатанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 696.7 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан ба үүнийг сумын ИТХ-аар нэмэгдүүлж, 1,367.8 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 1,380.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №7. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	Үйл ажиллагааны орлого	8.0	8.1	(0.1)	100.7%
2	Хадгаламжийн хүүгийн орлого	30.4	37.8	(7.3)	124.1%
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	9.0	26.4	(17.4)	293.4%
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	2.3	4.6	(2.2)	195.7%
5	Галт зэвсгийн албан татвар	3.8	3.8	(0.04)	101.1%
6	Улсын тэмдгийн хураамж	2.0	2.7	(0.7)	133.8%
7	Хог хаягдлын хураамж	28.7	12.9	15.8	44.8%
8	Түгээмэл тархацтай ашигт малтмал	1,235.0	1,235.0	-	100.0%
9	Хүү торгуулийн орлого	27.0	27.8	(0.8)	102.8%
10	Бусад нийтлэг төлбөр хураамж	14.0	15.5	(1.5)	110.8%
11	Төсөвт байгууллагын өөрийн орлого	7.5	6.2	1.3	82.1%
НИЙТ		1,367.8	1,380.6	(12.8)	100.9%

Эх сурвалж: Хатанбулаг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 7 нэр төрлийн орлого 28.5 сая төгрөгөөр давж, 2 нэр төрлийн орлого 17.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлого давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд,

- Үйл ажиллагааны орлого төлөвлөсөн дүнгээс 0.1 сая төгрөгөөр давсан нь сүүлийн хагас жилд үйл ажиллагаа эрхлэгчдийн тоо нэгээр нэмэгдсэнтэй холбоотой байна,
- Хадгаламжийн хүүгийн орлого 7.3 сая төгрөгөөр давсан нь хадгаламж эзэмшигч иргэдийн тоо болон иргэдийн хадгаламжийн мөнгөн дүн нэмэгдсэнтэй холбоотой байна,
- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 17.4 сая төгрөгөөр давсан нь төлөвлөгөөнд тусгагдаагүй, эх орны хишиг, ноос, арьс ширний урамшууллаас татвар суутгасан,
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.7 сая төгрөгөөр давсан нь Ханги хилийн боомт болон зам дагуух газрыг үйлдвэр үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх дуудлага худалдаанд төлөвлөсөн тооноос илүү иргэд, аж ахуй нэгж оролцсон байна,

Орон нутгийн орлого дараах шалтгааны улмаас тасарсан байна. Үүнд,

- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 15.8 сая төгрөгөөр тасарсан нь Ханги хилийн боомтод байрших тээврийн компаниуд цар тахлын улмаас үйл ажиллагаа явуугүйтэй холбоотой байна.
- Төсөвт байгууллагын өөрийн орлого 1.3 сая төгрөгөөр тасарсан нь сумын ЗДТГ-ын эзэмшдэг орон сууцыг сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор сурагчдын эцэг, эх түрээслээгүй байна.

Үүнээс аймгийн төсөвт 28.8 сая төгрөгийг төвлөрүүлэхээр аймгийн ИТХ-аас баталсан ба гүйцэтгэлээр 28.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлээгүй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан 3,552.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,411.5 сая төгрөгийг урсгал зардалд, 1,140.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,711.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,514.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 29.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 102.7 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 98.9 сая төгрөгийн урьд оны үлдэгдлээс, 95.2 сая төгрөгийг хандив тусламжаас, нийт 3,552.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,697.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1,483.2 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 29.5 сая төгрөгийг, нийт 3,210.5 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 44.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 74.2 сая төгрөг, хандив тусламжаас 80.0 сая төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 23.2 сая төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 43.7 сая төгрөгөөр тасарсан нь сум хөгжүүлэх сангийн орлого 22.7 сая, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх орлого 4.5 сая, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлого 1.3 сая, хандив тусламжаас бүрдүүлэх орлого 15.2 сая төгрөгөөр тасарснаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардал 3,292.5 сая төгрөг буюу 92.7 хувьтай /259.5 сая төгрөгийн хэмнэлттэй/ байгаа нь урсгал санхүүжилтийг 44.7 сая төгрөгөөр дутуу олгосон, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө 82.3 сая төгрөгөөр, нөхөн сэргээлтийн тусгай дансыг төлөвлөсөн дүнгээс 11.0 сая төгрөгөөр, ОНХС-ийн хөрөнгийг 24.8 сая төгрөгөөр дутуу зарцуулснаас, мөн зарим зардлын хэмнэснээс шалтгаалсан байна. Үүнд:

- Түлш халаалтын зардлыг 45.6 сая төгрөгөөр хэмнэсэн нь тус сумын төсөвт байгууллагуудыг 2020 онд төвлөрсөн халаалтад холбохоор төлөвлөж, түлш халаалтын зардлын төсвийн тооцооллыг хийсэн боловч 2020 оны 10 дугаар сар хүртэл төвлөрсөн халаалтад холбогдоогүйтэй байна.
- Хоол, хүнсний зардлыг 47.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь цар тахлын улмаас хүүхдийн цэцэрлэг болон сургуулийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна. Тухайлбал, сургуулийн хоол, хүнсний зардал 30.1 сая төгрөгөөр, цэцэрлэгийн хоолны зардал 17.2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 58.8 сая төгрөгийг улсын, 6.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 159.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 62.5 сая, нийт 221.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсний зардалд 0.2 сая, хангамж, бараа материалын зардалд 4.1 сая, нормативт зардалд 15.7 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 8.3 сая, томилолтын зардалд 1.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 164.6 сая, бараа ажил үйлчилгээний зардалд 23.8 сая төгрөг, тэтгэмж, урамшууллын зардалд 0.6 сая, нийт 218.7 зарцуулж, үлдэгдэл 2.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 139 мэдээллээс 128 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сан, 5 ахмадын сан, 1 тусгай сангийн нийт 14 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага, сан түүврээр хамрагдсан, 1 байгууллагад итгэл үзүүлэн байгууллага аудитад хамрагдаагүй байна. Байгууллагын 5 ахмадын сан болон нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулаагүй, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ болон холбогдох ТШЗ-ын санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 3 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн ба зөрчилтэй дүгнэлт авсан байгууллага үгүй болно.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд алдаа, зөрчил илрээгүй ба залруулга хийгдээгүй, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 162.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 155.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, 0.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг хүргүүллээ.

Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчтэй авлагын тооцоо нийлээгүй 155.3 сая төгрөгийн зөрчилд тус сангийн аудитыг гүйцэтгэх явцад албан шаардлага хүргүүлсэн. Уг зөрчлийг төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад арилгасан учир ТТЗ-ын аудитын тайланд зөрчилд тооцсон боловч, аудитын явцад залруулсан учир дүгнэлт гаргахад зөрчлийн дүнд нөлөөлөхгүй гэж үзлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант оны төсвийн төслийг боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлэх ажил хийгдээгүй байна. Иймд төсвийн төсөл, тухайлбал, сумын татварын ба татварын бус орлогын тооцоолол, үндэслэл бүхий төслийг боловсруулж байх шаардлагатай байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020 он	Аудитын нэр:	Хатанбулаг сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Мянган төгрөгөөр
Аудитын код:	ДГА-2021/3/СТА-ТТЗ	Шалгагдсан байгууллагын нэр:	Хатанбулаг сумын төсвийн төвлөрүүлэн захирагч	

№	Төсвийн шууд захирагч	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Аудит хийх хэлбэр	Санал, дүгнэлтийн хэлбэр	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
							Албан тушаал	Овог нэр
А		1	2	3			4	5
1	Хатанбулаг сумын ЗДТГ	Шатахууныг бараа материалд орлого авахгүй шууд зардалд бүртгэсэн	701.3	Аудитын явцад залруулав	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	ЗДТГ-ын дарга	Т.Цэцэгсүрэн
2		Зардлыг зөрүүтэй тайлагнасан буюу шуудан холбооны зардлыг бичиг хэргийн зардалд бүртгэсэн	512.0	Аудитын явцад залруулав				
3		Ноолуур борлуулсны орлого болох 444.6 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн боловч ноолуурыг бараа материалын дансанд бүртгээгүй байна.	444.6	Аудитын явцад залруулав				
4		Тайлант нийт төвлөрүүлэх түрээсийн орлогоос 2 иргэн 250.8 мянган төгрөгийн орон сууц түрээсэлсний төлбөрөө төлөөгүй байна.	250.8	Төлбөрийн акт тогтоох				
5		Тайлант онд байр түрээслүүлсний орлого нийт 9,569,5 мянган төгрөгийг бүрдүүлсэн боловч 4,353.3 мянган төгрөгийг орон өмчийн дансанд шилжүүлж 431.5 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн байна.	431.5	Төлбөрийн акт тогтоох				
6		Тайлант онд 7,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч 5,660.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь 11.2 хувиар тасарсан байна.	1,339.2	Зөвлөмж өгөх				
7	СХС	Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг буруу тайлагнасан байх	3,713.3	Аудитын явцад залруулав	Хэсэгчлэн аудит хийх		Засаг дарга, нягтлан бодогч	С.Эрдэнэболд, Б.Чаминчулуу
8		2020.12.31-ний байдлаар нийт 20 зээлдэгчийн 155309,1 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	155,309.1	Албан шаардлага өгөх				
9	Хатанбулаг сумын цэцэрлэг	Элэгдлийг дахин тооцоолоход нэг хөрөнгө 58.6 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй байна	58.6	Залруулга	Хэсэгчлэн аудит хийх		Нягтлан бодогч	
10	Хатанбулаг сумын сургууль	Тайлант хугацааны эцэст авлагын үлдэгдэлтэй ажилласан	-	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Захирал	П.Намжилмаа
11	Хатанбулаг сумын эрүүл мэндийн төв	Иргэд, ААН байгууллагаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй /цахим Е-баримтын бүрдлийг ханган ажиллаагүй/	-	Зөвлөмж өгөх	Санал дүгнэлт гаргах	Зөрчилгүй	Дарга, нягтлан бодогч	Ж.Цэмаа Ө.Одсүрэн
12	Хатанбулаг сумын соёлын төв	Алдаа, зөрчил илрээгүй	-		Хэсэгчлэн аудит хийх			
13	Хатанбулаг сумын ОНХС	Алдаа, зөрчил илрээгүй	-		Хэсэгчлэн аудит хийх			
14	Хатанбулаг сумын ИТХ	Итгэл үзүүлсэн	-		Итгэл үзүүлсэн			
НИЙТ			162,760.4					